

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад
суугаа Элчин сайдыг эгүүлэн татах, зарим улсад суух
Элчин сайд нарыг томилох саналын тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвшингийн Бадралыг эгүүлэн татах, Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямаагийн Энхболдыг;
2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашнямын Энхтайваныг;
3. Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дааданхүүгийн Батбаатарыг тус тус томилох саналыг танилцуулж байна.

Эгүүлэн татагдаж буй Элчин сайд Т.Бадралын томилолтын хугацаа нь дууссан. Харин Бүгд Найрамдах Индонез Улсын нийслэл Жакарта хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар Улсын Их Хурал 2013 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 43 дугаар тогтоолоор шийдвэрлэн 2014-2017 онд үйл ажиллагаа эрхлэн явуулсан боловч эдийн засаг, санхүүжилтээс шалтгаалан Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар тус Элчин сайдын яамыг бүрмөсөн татан буулгахгүйгээр санхүүжилтиг нь зогсоож, санхүүгийн бололцоотой болсон үед сэргээн ажиллуулахаар шийдвэрлэсэн. Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суугаа Элчин сайдын яамны үйл ажиллагааг 2024 оноос сэргээхээр төлөвлөж, айлын талаас зохих зөвшөөрлийг авсан бөгөөд Элчин сайд томилогдоогүй байгаа болно.

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайд яамаа нээн ажиллуулахаар Улсын Их Хурал 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр шийдвэрлэсэнтэй холбогдуулан тус улсад суух Элчин сайдыг шинээр томилох шаардлага байна.

Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсрсан суугаа улс, олон улсын байгууллагадаа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгааг хийж, төр, засгийн байгууллагыг мэдээллээр хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, хоёр болон олон талын харилцааны асуудлаар яриа, хэлэлцээ хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг олон улсын

Эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладагаас гадна тэргүүлж буй Дипломат төлөөлөгчийн газрынхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшигчид нь төрийн болон дипломат албананд олон жил ажилласан, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршлагатай, гадаад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан төрийн албан хаагчид юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР